



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2025.03.28 № ЗГ-1/41  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000254000269



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201

Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,

Цахим шуудан: info@cabinet.gov.mn,

Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.03.27 № НХТ/839

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
хугацааг товлох тухай

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалыг хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт <sup>23</sup> хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Н.УЧРАЛ

000255004439



**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД**

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,  
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,  
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,  
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2025.03.26 № 01/2115

танай 2025.03.24 ны № 01/856 -Т

**АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН  
САЙД Ц.ТУВААН ТАНАА**

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон бусад хууль, тогтоомжийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу хянан үзэхэд төсвийн зардал нэмэгдүүлэх, орлого бууруулах үр дагавартай байгаа тул тус хуулийн төсөлд өгсөн саналыг тусгасны үндсэн дээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй байна гэж үзэв.

Хүндэтгэсэн,

**Б.ЖАВХЛАН**



**9761000623**



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас/Факс: (976-51) 26 75 33,  
Цахим шуудан: info@mojha.gov.mn,  
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2025. 03. 26 .№ 1/1545 -  
танай \_\_\_\_\_-ны № 01/858 -Т

**АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН  
САЙД Ц.ТУВААН ТАНАА**

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.

О.АЛТАНГЭРЭЛ

15160103  
Асрвал 2025

151601036



محمد محمد

م.م. محمد محمد

بى كىدىن كىدىن كىدىن كىدىن ..

بى كىدىن كىدىن كىدىن كىدىن ..  
بى كىدىن كىدىن كىدىن كىدىن ..  
بى كىدىن كىدىن كىدىن كىدىن ..  
بى كىدىن كىدىن كىدىن كىدىن ..

بى كىدىن كىدىن كىدىن كىدىن ..

بى كىدىن كىدىن كىدىن كىدىن ..

بى كىدىن كىدىن كىدىن كىدىن ..

بى كىدىن كىدىن كىدىن كىدىن ..

بى كىدىن كىدىن كىدىن كىدىن ..

بى كىدىن كىدىن كىدىن كىدىن ..

بى كىدىن كىدىن كىدىن كىدىن ..



بى كىدىن كىدىن كىدىن كىدىن ..



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас/Факс: (976-51) 26 75 33,  
Цахим шуудан: info@mojha.gov.mn,  
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2025.03.26. № 1/1544  
танай \_\_\_\_\_ -ны № 01/819 -Т

**АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН  
САЙД Ц.ТУВААН ТАНАА**

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 19<sup>1</sup> дүгээр зүйлийн 19<sup>1.1</sup> дэх хэсэгт зааснаар Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагыг хангасан байна.

О.АЛТАНГЭРЭЛ

151601603



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭС

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 14 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

“10.ХЭЛЭЛЦСЭН нь: Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



## УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

### Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

#### 1.1. Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ., ...Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж заасан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2.1-д “Нэмүү өртөг шингээсэн уул уурхай, стратегийн мега төслүүд, боловсруулах аж үйлдвэр, хөдөө аж ахуй, эрчим хүч, тээвэр, логистик, төрөлжсөн аялал жуулчлал, түүнийг дагасан үйлчилгээ, жижиг, дунд үйлдвэрлэл, мэдлэгжсэн бүтээлч үйлдвэрлэлийг эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.3.6.1-д “Уул уурхайн салбарын түүхий эдийн боловсруулалтын түвшин болон хүнд үйлдвэрлэлийн хүчин чадлыг өсгөж, экспортын орлогыг нэмэгдүүлнэ.” гэж тус тус заасан.

#### 1.2. Практик шаардлага

Уул уурхайн салбар 2024 оны жилийн эцсийн байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүний 26 хувь, аж үйлдвэрийн салбарын 72 хувь, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 81 хувь, экспортын орлогын 94 хувь, төсвийн орлогын 34 хувийг тус тус бүрдүүлсэн.

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2025 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр 3,715.8 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 120.4 (3.1%) сая ам.доллаароор буурсан байна. Экспорт, импортоос давамгайлж 294.0 сая ам.доллаароор өссөн үзүүлэлттэй гарсан боловч экспортын орлого өмнөх оны мөн үеэс 235.4 (10.5%) сая ам.доллаароор буурч 2,004.9 сая ам.долларын гүйцэтгэлтэй байна.

Одоогийн байдлаар уул уурхайн бүтээгдэхүүнийг спот, форвард гэрээний дагуу биржээр дамжуулан арилжиж байгаа бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрөөс 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийг хүртэл 43.0 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг нийт 17.07 их наяд төгрөгөөр арилжаалаад байна. “Монголын хөрөнгийн бирж” ХК-д бүртгэлтэй уул уурхайн бүтээгдэхүүний худалдагч 21 компани, 471 гэрээ байгуулсан худалдан авагчид бүртгэлтэй байна. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаагаар хамгийн их бүтээгдэхүүн арилжсан сар нь 2024 оны 04 дүгээр сард бөгөөд нийт 55 удаагийн арилжаагаар 4.2 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг 951.5 тэрбум төгрөгөөр арилжаалсан байна.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны дүнгээс үзэхэд тухайн бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэж, үнэ өсөх үед арилжаа өссөн бөгөөд 2023 оны 12 дугаар сард нүүрсний үнэ 816,000 төгрөг хүрэх үед биржийн арилжаагаар 1.9 их наяд төгрөгийн нүүрс арилжсан байна. 2025 оны 02 дугаар сарын байдлаар нүүрсний үнэ 30%-иар буурч 568,800 төгрөг болоход биржийн арилжааны тоо өмнөх оны мөн үеэс 9 дахин буурсан байна. Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр 2024 оны 1 болон 2 дугаар сард нийт 3.9 сая тонн нүүрсийг 1.8 их наяд төгрөгөөр арилжаалж байсан ба тухайн хугацаанд нэг арилжаанд дунджаар 6 худалдан авагчид оролцдог байсан бол 2025 оны 1, 2 дугаар саруудад нийт 428.8 мянган тонн нүүрсийг 122.9 тэрбум төгрөгөөр арилжаалаад байгаа ба нэг арилжаанд дунджаар 1-2 худалдан авагчид оролцож байгаа нь эрэлт огцом буурсан байгааг илтгэж байна.

Монгол Улсын экспортын гол нэрийн бүтээгдэхүүний эрэлт дэлхийн зах зээлд буурах хандлагатай байгаа нь өнөөгийн нөхцөл байдалд нийцүүлсэн хууль, эрх зүйн уян хатан зохицуулалтыг тусгах шаардлага үүсээд байна.

Түүнчлэн, Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгасан “Гашуунсухайт-Ганцмод, Ханги-Мандал, Шивээхүрэн-Сэхээ хилийн боомтуудын хил дамнасан холболтын төмөр зам, нүүрс-хими, кокс химийн цогцолбор, гангийн цогцолбор” зэрэг мега төслүүдийн бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэхэд Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн зарим зохицуулалт хүндрэл үүсгэж байна.

Тодруулбал, тус хуулийн үйлчлэх хүрээ нь уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортлоход буюу гадаадын зах зээл рүү нийлүүлэхэд биржээр дамжуулан худалдан борлуулах, түүнтэй холбоотой гэрээ, хэлцэл байгуулах харилцааг зохицуулахаар заасан нь дотоодын баяжуулах, боловсруулах үйлдвэрт бүтээгдэхүүн нийлүүлэх эрх зүйн орчныг орхигдуулсан байна. Тодруулбал, дотоодын баяжуулах, боловсруулах үйлдвэрт бүтээгдэхүүн нийлүүлэх эрх зүйн орчин тодорхой бус байгаагаас үүдэн ашиглалтын тусгай зөвшөөрөлгүй баяжуулах, боловсруулах үйлдвэрүүд түүхий эдийн хомсдолд орж, үйл ажиллагаа нь зогсонги байдалд байна.

Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх баталгааны хэлэлцээрийн дагуу Монгол Улс цацраг идэвхт ашигт малтмалын борлуулалтын мэдээ, тайланг Олон Улсын Атомын Энергийн Агентлагт хүргүүлэх үүрэг хүлээсэн бөгөөд цаашид биржээр арилжаалсан тохиолдолд холбогдох мэдээллийг тус агентлагт хүргүүлж байх хуулийн зохицуулалтыг тусгах шаардлагатай байна.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээд бүтээгдэхүүнээ заавал биржээр

арилжаалах, мөн биржийн хүргэлтийг хил нөхцөлөөр, үнийг хил залгаа улсын хилийн боомтын үнэ байхаар заасан нь аж ахуйн нэгжийн орлогод хязгаарлалт тогтоох нөхцөл болж байна. Өөрөөр хэлбэл, бүтээгдэхүүний зах зээлийн эрэлт буурч, үнэ унах үед эдгээр аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын орлогод сөргөөр нөлөөлж, улмаар Үндэсний баялгийн санг арвижуулахад бэрхшээл учруулж байна. Тухайлбал, Ашигт малтмал, газрын тосны газрын статистик мэдээлэлд Монгол Улс дотооддоо хайлуур жонш, нүүрс, төмрийн хүдэр баяжуулах нийт 47 үйлдвэр ажиллаж байгаа хэдий ч түүхий эдийн хомсдолд орж, үйл ажиллагаа нь зогсонги байдалд байна гэжээ.

Түүнчлэн, тус хуулийн зарим зохицуулалтын улмаас уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаанд дараах хүндрэлүүд үүсэж байна. Үүнд:

- Дотоодын баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдэд бүтээгдэхүүн борлуулах боломжгүй болсон;

- Биржээр арилжаалах бүтээгдэхүүний үнийг дуудлага худалдааны үнээр хатуу тогтоосны улмаас зарим гэрээний нийлүүлэлт хийх боломжгүй болж, алдагдал хүлээх болсон;

- Эрчим хүчний системд нүүрс нийлүүлэгч уурхайнуудын экспорт зогсож, алдагдал нь нэмэгдсэн;

- Биржийн арилжааг хил нөхцөлөөр гүйцэтгэж байгаатай холбоотойгоор нийлүүлэлт хангалтгүй хийгдэж, худалдан авагчийн итгэлийг алдаж, гэрээний үүрэг зөрчигдөх болсон;

- Уул уурхайн бүтээгдэхүүнийг урт хугацаанд борлуулах боломжгүй болж, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн зах зээлийн үнэлгээ буурах болсон.

Иймд, манай улсын уул уурхайн бүтээгдэхүүний олборлолт, борлуулалтын бодит нөхцөл байдал болон дэлхий нийтийн чиг хандлага, бусад улсын сайн туршлагыг харгалзан, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн чадавхыг сайжруулж, арилжааг нэмэгдүүлэх зорилгоор Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд зохих нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүсээд байна.

### **Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээний талаар**

Хуулийн төсөлд дараах асуудлыг тусгана. Үүнд:

- Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн үйлчлэх хүрээнд өөрчлөлт оруулж, уул уурхайн бүтээгдэхүүнийг гадаад болон дотоодын зах зээлд биржээр дамжуулан арилжих зохицуулалтыг тусгах;

- Биржээр арилжаалах бүтээгдэхүүний үнийг зах зээлийн үнийн индексийн хөдөлгөөнд тулгуурлан өөрчлөлт оруулах боломжийг бүрдүүлэхээр тусгах;

- Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тогтвортой үйл ажиллагаа явуулах боломжийг олгох зорилгоор харилцан ашигтай бүтээгдэхүүн худалдах гэрээг байгуулах зохицуулалтыг тусгах;

- Биржийн арилжааны үнийг Олон Улсын худалдааны танхимаас гаргасан худалдааны журамд заасны дагуу зарлах талаар тусгах;

- Цацраг идэвхт ашигт малтмалыг биржээр арилжаалсан тохиолдолд борлуулалтын мэдээллийг Олон Улсын Атомын Энергийн Агентлагт хүргүүлж байх зохицуулалтыг тусгах;

- Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд байгуулсан “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлын нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай” хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах зорилгоор Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийг хүчингүй болгох зохицуулалтыг тусгана.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, эрх зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар**

Хуулийн төсөл батлагдсанаар нийгэмд, эдийн засагт дараах эерэг үр дагаврууд бий болно. Үүнд:

-Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн амжилттай арилжааны тоо нэмэгдэж, борлуулалт тогтворжин, валютын орох урсгал нэмэгдэх;

-Дотоодын баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдэд түүхий эд нийлүүлэх боломж бүрдсэнээр үйл ажиллагаа нь жигдэрч, нэмүү өртөг шингэх, ажлын байр өсөх, улмаар Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “нүүрс-хими, кокс химийн цогцолборын төсөл, гангийн цогцолборын төсөл” зэрэг төслүүд хэрэгжих нөхцөл бүрдэх;

-Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлын нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай” хэлэлцээрийн хэрэгжилт хангагдах;

-Цацраг идэвхт ашигт малтмалын борлуулалтын үйл ажиллагаанд тавигдах хяналт сайжрах;

-Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн борлуулах бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдэж, Үндэсний баялгийн сангийн орлогын хэмжээ нэмэгдэх зэрэг боломж бүрдэнэ.

**Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах хүчингүй болгох хуулийн талаарх санал**

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн, Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагыг ханган боловсруулна.

Хуулийн төсөлтэй уялдуулан Цөмийн энергийн тухай, Зөвшөөрлийн тухай хууль, Улсын Их Хурлын 2024 оны 13 дугаар тогтоолд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулна.

---o0o---

## ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

*Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар*

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. ... Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж хуульчилсан.

Монгол Улсын Үндсэн хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын Их хурал 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг, 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг тус тус баталсан. Мөн 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг баталсан ба хөтөлбөрт “Гашуунсухайт-Ганцмод, Ханги-Мандал, Шивээхүрэн-Сэхээ хилийн боомтуудын хил дамнасан холболтын төмөр зам, нүүрс-хими, кокс химийн цогцолбор, гангын цогцолбор” зэрэг мега төслүүдийн бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэхээр тусгаж, үүний дагуу Монгол Улсын Засгийн газраас холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсээр байна.

Гэсэн хэдий ч холбогдох эрх зүйн зохицуулалтуудын хийдэл болон өөр хоорондын уялдаагүй байдлаас үүдэн уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр дамжуулан арилжаалах үйл ажиллагаа зогсонги байдалд орох, биржийн арилжаанд оролцогч аж ахуйн нэгжүүдийн орлогыг хязгаарлах зэрэг сөрөг үр дагаврууд байсаар байгаа нь цаашлаад Үндэсний баялгийн санг арвижуулахад бэрхшээл үүсгэх эрсдэлтэй байна.

Иймд Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, Үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулах, эрдэс баялгийг олон улсын стандартын дагуу ашиглаж борлуулах, түүнээс олох орлогыг үндэсний эдийн засгийн бие даасан байдлыг хангах, олон тулгуурт эдийн засгийг дэмжих хүрээнд Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр бэлтгэлээ.

**Нэг. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ, шаардлага**

Уг хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг дараах үндэслэлүүдээр тайлбарлаж байна. Үүнд:

Уул уурхайн салбар 2024 оны жилийн эцсийн байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүний 26 хувь, аж үйлдвэрийн салбарын 72 хувь, гадаадын шууд хөрөнгө

оруулалтын 81 хувь, экспортын орлогын 94 хувь, төсвийн орлогын 34 хувийг тус тус бүрдүүлсэн.

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2025 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр 3,715.8 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 120.4 (3.1%) сая ам.доллаароор буурсан байна. Экспорт, импортоос давамгайлж 294.0 сая ам.доллаароор өссөн үзүүлэлттэй гарсан боловч экспортын орлого өмнөх оны мөн үеэс 235.4 (10.5%) сая ам.доллаароор буурч 2,004.9 сая ам.долларын гүйцэтгэлтэй байна.

Одоогийн байдлаар уул уурхайн бүтээгдэхүүнийг спот, форвард гэрээний дагуу биржээр дамжуулан арилжиж байгаа бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрөөс 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийг хүртэл 43.0 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг нийт 17.07 их наяд төгрөгөөр арилжаалаад байна. “Монголын хөрөнгийн бирж” ХК-д бүртгэлтэй уул уурхайн бүтээгдэхүүний худалдагч 21 компани, 471 гэрээ байгуулсан худалдан авагчид бүртгэлтэй байна. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаагаар хамгийн их бүтээгдэхүүн арилжсан сар нь 2024 оны 04 дүгээр сард бөгөөд нийт 55 удаагийн арилжаагаар 4.2 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг 951.5 тэрбум төгрөгөөр арилжаалсан байна.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны дүнгээс үзэхэд тухайн бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэж, үнэ өсөх үед арилжаа өссөн бөгөөд 2023 оны 12 дугаар сард нүүрсний үнэ 816,000 төгрөг хүрэх үед биржийн арилжаагаар 1.9 их наяд төгрөгийн нүүрс арилжсан байна. 2025 оны 02 дугаар сарын байдлаар нүүрсний үнэ 30%-аар буурч 568,800 болоход биржийн арилжааны тоо өмнөх оны мөн үеэс 9 дахин буурсан байна. Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр 2024 оны 1 болон 2 дугаар сард нийт 3.9 сая тонн нүүрсийг 1.8 их наяд төгрөгөөр арилжаалж байсан ба тухайн хугацаанд нэг арилжаанд дунджаар 6 худалдан авагчид оролцдог байсан бол 2025 оны 1, 2 дугаар саруудад нийт 428.8 мянган тонн нүүрсийг 122.9 тэрбум төгрөгөөр арилжаалаад байгаа ба нэг арилжаанд дунджаар 1-2 худалдан авагчид оролцож байгаа нь эрэлт огцом буурсан байгааг илтгэж байна.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн дагуу дотоодын баяжуулах боловсруулах үйлдвэрт бүтээгдэхүүн нийлүүлэх эрх зүйн орчин тодорхой бус байгаагаас үүдэн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй баяжуулах боловсруулах үйлдвэрүүд түүхий эдийн хомсдолд орсноор үйл ажиллагаагаа хэвийн явуулахад хүндрэлтэй болж, зогсонги байдал үүсээд байна. Ашигт малтмал, газрын тосны газарт бүртгэгдсэнээр ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй нийт 47 (хайлуур жонш, нүүрс, төмрийн хүдрийн) баяжуулах үйлдвэр ашиглалтад орсон байна.

Мөн уул уурхайн бүтээгдэхүүний чанар, эрэлт нийлүүлэлтийн харьцаанаас хамаарч бүтээгдэхүүний үнэ өөрчлөгдөх хэрэгцээ шаардлага үүсдэг. Гэвч биржээр арилжаалах уул уурхайн бүтээгдэхүүний үнэ тогтоох асуудлыг уян хатан бус, хатуу байдлаар зохицуулсны улмаас зарим гэрээний нийлүүлэлт хийгдэх боломжгүй болж, алдагдал хүлээх болсон.

Түүнчлэн, дэлхийн дахинд эрчим хүчний аюулгүй байдлыг хангах, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх хүрээнд цэвэр эрчим хүчний хэрэглээ өсөхийн хэрээр цацраг идэвхт ашигт малтмалын хэрэгцээ шаардлага нэмэгдэж байна. Үүнтэй холбогдуулан Засгийн газраас олборлолтод бэлтгэгдсэн цацраг идэвхт ашигт малтмалын ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулахаар ажиллаж байна.

Монгол Улс цацраг идэвхт ашигт малтмалын борлуулалтын мэдээ, тайланг олон улсын гэрээ конвенцоор хүлээсэн үүргийн дагуу Олон Улсын Атомын Энергийн Агентлагт хүргүүлэх шаардлагатай бөгөөд энэ хүрээнд цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох, үйл ажиллагаанд хяналт тавих харилцааг боловсронгуй болгох, шат дамжлагыг бууруулах, нэгдсэн тогтолцоонд оруулах шаардлагатай байна.

### **Хоёр. Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дараах 3 зүйлтэйгээр боловсрууллаа. Үүнд:

1 дүгээр зүйлд төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь боловсруулалт, баяжуулалт хийхгүйгээр дамжуулан борлуулалт хийхээс бусад тохиолдолд дотоодын баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдэд уул уурхайн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг нэмэгдүүлэх зорилгоор биржээр дамжуулан арилжих, мөн уул уурхайн бүтээгдэхүүний чанар болон зах зээлийн үнийн индексийн хөдөлгөөнд тулгуурлан гэрээний үнэд өөрчлөлт оруулах талаар гэрээнд тусгах, мөн уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр дамжуулан дотоодын баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдэд арилжих журам болон үнэд өөрчлөлт оруулахтай холбогдох аргачлалыг Засгийн газар батлах тухай, цацраг идэвхт ашигт малтмалын борлуулалтын талаар мэдээллийг Цөмийн энергийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нэгтгэн хяналт тавьж, Олон Улсын Атомын Энергийн агентлагт хүргүүлэх зэрэг зохицуулалтыг тус тус хуулийн төсөлд нэмж оруулахаар боловсруулсан.

2 дугаар зүйлд Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг болон 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн зохицуулалтыг өөрчлөн найруулсан. Энэ хүрээнд стратегийн орд эзэмшигч төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь харилцан ашигтай, тогтвортой, урт хугацаанд бүтээгдэхүүн худалдах гэрээг байгуулах тохиолдолд Монгол Улсын Их Хурлын шийдвэрийн дагуу байгуулах, мөн биржийн арилжааны үнийг Олон Улсын худалдааны танхимаас гаргасан худалдааны нөхцөлөөр зарлах тухай зохицуулалтуудыг тус тус тусгасан.

3 дугаар зүйлд Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд оруулж байгаа нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан тус хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийг хүчингүй болгохоор тусгасан.

### **Гурав. Хуулийн төсөл батлагдсанаар хүлээгдэж буй үр дүн**

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар нийгэмд эдийн засагт дараах эерэг үр дагаврууд бий болно. Үүнд:

Уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр арилжаалах зохицуулалт сайжирснаар биржийн амжилттай арилжааны тоо нэмэгдэн, уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалт нэмэгдэнэ.

Дотоодын баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдэд түүхий эд нийлүүлэх зохицуулалтыг бий болгосноор ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй баяжуулах боловсруулах үйлдвэрүүдийн үйл ажиллагаа явуулах нөхцөл, ажлын байрны тоо,

нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний гарц нэмэгдэнэ. Ингэснээр “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгагдсан “нүүрс-хими, кокс химийн цогцолборын төсөл, гангийн цогцолборын төсөл” зэрэг төслүүд хэрэгжих нөхцөлийг бүрдэнэ.

Цацраг идэвхт ашигт малтмалыг эдийн засгийн эргэлтэд оруулах, борлуулах, хяналт тавих эрх зүйн орчин сайжирч, Олон Улсын Атомын Энергийн Агентлагтай байгуулсан хэлэлцээрийн хэрэгжилт хангагдана.

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлын нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай” хэлэлцээрийн хэрэгжилт хангагдах нөхцөл бүрдэнэ.

Мөн төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн борлуулах уул уурхайн бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдэж, Үндэсний баялгийн санг арвижуулах нөхцөл бүрдэнэ.

### **Дөрөв. Дагалдаж өөрчлөлт оруулах хууль тогтоомжийн төсөл**

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн, Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу боловсрууллаа.

### **Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй уялдуулан Цөмийн энергийн тухай хуульд Цөмийн энергийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх талаар тусгана.

Мөн цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг Засгийн газрын зөвшөөрлийн дагуу олгох талаар тусгана.

### **Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

Цацрагийн үүсгүүртэй холбоотой тусгай зөвшөөрлийг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгох зохицуулалтыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрхлэх асуудалд хамруулахаар тусгана.

### **Монгол Улсын Их Хурлын 2024 оны 13 дугаар тогтоолд нэмэлт оруулах тухай тогтоолын төсөл**

Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөлтэй уялдуулан Монгол Улсын Их Хурлын 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 13 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” хэсэгт “-Цөмийн энергийн газар” гэж нэмэхээр тусгана.

## ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Үндсэн хуульд байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээх талаар тусгагдсан. Үүний хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол Улсын Их Хурал 2022 онд Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг, 2024 онд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг тус тус баталсан.

Уул уурхайн салбар 2024 оны жилийн эцсийн байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүний 26 хувь, аж үйлдвэрийн салбарын 72 хувь, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 81 хувь, экспортын орлогын 94 хувь, төсвийн орлогын 34 хувийг тус тус бүрдүүлсэн.

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2025 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр 3,715.8 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 120.4 (3.1%) сая ам.доллараар буурсан байна. Экспорт, импортоос давамгайлж 294.0 сая ам.доллараар өссөн үзүүлэлттэй гарсан боловч экспортын орлого өмнөх оны мөн үеэс 235.4 (10.5%) сая ам.доллараар буурч 2,004.9 сая ам.долларын гүйцэтгэлтэй байна.

Одоогийн байдлаар уул уурхайн бүтээгдэхүүнийг спот, форвард гэрээний дагуу биржээр дамжуулан арилжиж байгаа бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрөөс 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийг хүртэл 43.0 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг нийт 17.07 их наяд төгрөгөөр арилжаалаад байна. “Монголын хөрөнгийн бирж” ХК-д бүртгэлтэй уул уурхайн бүтээгдэхүүний худалдагч 21 компани, 471 гэрээ байгуулсан худалдан авагчид бүртгэлтэй байна. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаагаар хамгийн их бүтээгдэхүүн арилжсан сар нь 2024 оны 04 дүгээр сард бөгөөд нийт 55 удаагийн арилжаагаар 4.2 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг 951.5 тэрбум төгрөгөөр арилжаалсан байна.

Гэсэн хэдий ч дээрх эрх зүйн зохицуулалтуудын хийдэл болон хоорондын уялдаагүй байдлаас үүдэн уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр дамжуулан арилжаалах үйл ажиллагаа зогсонги байдалд орох, биржийн арилжаанд оролцогч аж ахуйн нэгжүүдийн орлогыг хязгаарлах зэрэг сөрөг үр дагаврууд байсаар байгаа нь цаашлаад Үндэсний баялгийн санг арвижуулахад бэрхшээл үүсгэх эрсдэлтэй байна. Тухайлбал, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны дүнгээс үзэхэд тухайн бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэж, үнэ өсөх үед арилжаа өссөн бөгөөд 2023 оны 12 дугаар сард нүүрсний үнэ 816,000 төгрөг хүрэх үед биржийн арилжаагаар 1.9 их наяд төгрөгийн нүүрс арилжсан байна. 2025 оны 02 дугаар сарын байдлаар нүүрсний үнэ 30%-аар буурч 568,800 төгрөг болоход биржийн арилжааны тоо өмнөх оны мөн үеэс 9 дахин буурсан байна. Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр 2024 оны 1 болон 2 дугаар сард нийт 3.9 сая тонн нүүрсийг 1.8 их наяд төгрөгөөр арилжаалж байсан ба тухайн хугацаанд нэг арилжаанд дунджаар 6 худалдан авагчид оролцдог байсан бол 2025 оны 1, 2 дугаар саруудад нийт 428.8 мянган тонн нүүрсийг 122.9 тэрбум төгрөгөөр арилжаалаад байгаа ба нэг арилжаанд дунджаар 1-2 худалдан авагчид оролцож байгаа нь эрэлт огцом буурсан байгааг илтгэж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Гашуунсухайт-Ганцмод, Ханги-Мандал, Шивээхүрэн-Сэхээ хилийн боомтуудын хил дамнасан холболтын төмөр зам, нүүрс-хими, кокс химийн цогцолбор, гангын цогцолбор” зэрэг мега төслүүдийн бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэхэд Уул

уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн зарим зохицуулалт хүндрэл үүсгэж байна.

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжил нь эрдэс баялаг, уул уурхайн салбараас шууд хамааралтай бөгөөд уул уурхайн бүтээгдэхүүний олборлолт, борлуулалт, бүтээгдэхүүний үнэ болон гадаад зах зээлийн орчноос манай улсын эдийн засгийн нөхцөл байдал шууд хамаарч байна. Түүнчлэн, дэлхий нийтэд цэвэр эрчим хүчний шилжилтэд анхаарал хандуулж байгаатай уялдан уул уурхайн бүтээгдэхүүний зэх зээл дээрх эрэлт цаашид улам бүр буурах хандлагатай байна.

Мөн Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх баталгааны хэлэлцээрийн дагуу Монгол Улс цацраг идэвхт ашигт малтмалын борлуулалтын мэдээ, тайланг Олон Улсын Атомын Энергийн Агентлагт хүргүүлэх үүрэг хүлээсэн тул уг харилцааг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Иймд Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, Үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулах, эрдэс баялгийг олон улсын стандартын дагуу ашиглаж борлуулах, түүнээс олох орлогыг үндэсний эдийн засгийн бие даасан байдлыг хангах, олон тулгуурт эдийн засгийг дэмжих хүрээнд Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр бэлтгэлээ.

Энэхүү хуулийн төсөл нь 3 зүйлтэй бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай тус тус нийцсэн болно.

Хуулийн төсөлтэй уялдуулан Цөмийн энергийн тухай, Зөвшөөрлийн тухай хууль, Улсын Их Хурлын 2024 оны 13 дугаар тогтоолд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулна.

--ooOoo--

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

#### **1/10 дугаар зүйлийн 10.5, 10.6, 10.7 дахь хэсэг:**

“10.5.Энэ хуулийн 10.2-т заасан этгээд нь уул уурхайн бүтээгдэхүүний баяжуулалт, боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингээж, экспортлох зорилгоор дотоодын баяжуулах, боловсруулах үйлдвэрт биржээр дамжуулан арилжиж болно.

10.6.Энэ хуулийн 10.2-т заасан этгээд уул уурхайн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг нэмэгдүүлэхээс бусад зорилгоор дотоодод борлуулахыг хориглоно.

10.7.Ашигт малтмалын тухай хуулийн 35.11-д заасан ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон цахилгаан, дулаан үйлдвэрлэхэд ашиглагдах түлшийг нийлүүлэгч аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүний борлуулалтад энэ хуулийн 10.2 дахь хэсэг хамаарахгүй.”

#### **2/13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг:**

“13.4.Энэ хуулийн 14.7-д заасан мэдээллийг Цөмийн энергийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нэгтгэж, хяналт тавина.”

#### **3/14 дүгээр зүйлийн 14.6, 14.7 дахь хэсэг:**

“14.6.Уул уурхайн бүтээгдэхүүний чанар болон зах зээлийн үнийн индексийн хөдөлгөөнд тулгуурлан энэ хуулийн 14.3-т заасан үнэд өөрчлөлт оруулахаар гэрээнд тусгаж болно.

14.7.Цацраг идэвхт ашигт малтмалын борлуулалтын талаар мэдээллийг Цөмийн энергийн тухай хуулийн 47.1.1-д заасны дагуу Олон Улсын Атомын Энергийн агентлагт хүргүүлнэ.”

#### **4/16 дугаар зүйлийн 16.3, 16.4, 16.5 дахь хэсэг:**

“16.3.Уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр дамжуулан дотоодын баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдэд арилжих журмыг Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал болгосноор Засгийн газар батална.

16.4.Энэ хуулийн 14.6-д заасан үнэд өөрчлөлт оруулахтай холбогдох аргачлалыг батална.

16.5.Энэ хуулийн 14.1-д заасан бараа хүргэлтийн байршлыг батална.”

**2 дугаар зүйл.**Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг:**

“10.3.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь нийгэм, эдийн засгийн ач холбогдол бүхий томоохон төсөл, бүтээн байгуулалтын ажлуудыг хэрэгжүүлэх зорилгоор харилцан ашигтай, тогтвортой, урт хугацаанд бүтээгдэхүүн солилцох гэрээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын Их Хурал шийдвэрлэж болно.”

**2/14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг:**

“14.1.Биржийн арилжааны үнийг Олон Улсын худалдааны танхимаас гаргасан худалдааны бараа хүргэлтийн байршилтай уялдуулж тогтооно.”

**3 дугаар зүйл.**Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**ГАРЫН ҮСЭГ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар  
сарын ... - ны өдөр

Улаанбаатар  
хот

**ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Цөмийн энергийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“15.2. Дараах үйл ажиллагааг Засгийн газрын зөвшөөрснөөр цөмийн энергийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлнэ.”

**2 дугаар зүйл.**Цөмийн энергийн тухай хуулийн 11<sup>1</sup> дүгээр зүйлийн гарчиг, 11<sup>1.1</sup> дэх хэсэг, 12.1 дэх хэсэг, 14.1 дэх хэсэг, 28.2.6 дахь заалт, 28.2.7 дахь заалт, 28.2.8 дахь заалт, 32.2 дахь хэсэг, 34.7 дахь хэсэг, 36.1.5 дахь заалт, 43.4 дэх хэсэг, 48.1 дэх хэсгийн “төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “**төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллага**” гэж, 11 дүгээр зүйлийн гарчиг, 11.1 дэх хэсэг, 11.2 дахь хэсэг, 12.10 дахь хэсэг, 15.1 дэх хэсэг, 31.1 дэх хэсэг, 31.3 дахь хэсэг, 31.4 дэх хэсэг, 31.5 дахь хэсэг, 33.3 дахь хэсэг, 34.4.3 дахь заалт, 37.1.3 дахь заалт, 37.1.6 дахь заалт, 37.2.3 дахь заалт, 47.1.1 дэх заалтын “цөмийн энергийн комисс” гэснийг “цөмийн энергийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэж, 11<sup>2</sup> дүгээр зүйлийн гарчиг, 11<sup>2.1</sup> дэх хэсэг, 11<sup>2.2</sup> дахь хэсэг, 19.7 дахь хэсэг, 20<sup>1.8</sup> дахь хэсэг, 28.4.4 дэх заалт, 28.4.5 дахь заалт, 28.6.5 дахь заалт, 28.10 дахь хэсэг, 29.1 дэх хэсэг, 29.4 дэх хэсгийн “геологи, уул уурхайн” гэснийг “цөмийн энергийн” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Цөмийн энергийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5, 10.6 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**

Төсөл

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2025 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 8.20, 8.21, 8.22, 8.23 дахь хэсгийн “боловсролын” гэснийг “цөмийн энергийн” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

**“ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО,  
БҮТЦИЙН ЕРӨНХИЙ БҮДҮҮВЧ”-Д  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 13 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” хэсэгт “-Цөмийн энергийн газар” гэж нэмсүгэй.

2.Энэ тогтоолыг Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**

### АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮД

Д/д	Байгууллага	Албан тушаал	Овог, нэр
1.	Санхүүгийн зохицуулах хороо	Үнэт цаасны газрын дарга (зөвшилцсөнөөр)	Б.Дөлгөөн
2.	Хууль зүй, дотоод хэргийн яам	Хууль зүйн бодлогын газрын дарга	Н.Жамъянхүү
3.	Эдийн засаг, хөгжлийн яам	Хууль зүйн бодлогын газрын дарга	Л.Энх-Амгалан
4.	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	Эрдэс баялгийн бодлогын газрын дарга	Г.Намчинсүрэн
5.	Санхүүгийн зохицуулах хороо	Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (зөвшилцсөнөөр)	Ж.Мөнх-Оргил
6.	Сангийн яам	Төсвийн орлогын хэлтсийн дарга	Л.Ичинноров
7.	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	Хуулийн хэлтсийн дарга	Т.Ганбаатар
8.	“Эрдэнэс Монгол” ХХК	Гүйцэтгэх захирал	С.Наранцогт
9.	Эрдэнэс Тавантолгой” ХК	Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч	Х.Мөнхжаргал
10.	“Монголын хөрөнгийн бирж” ХК	Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Б.Дөлгөөн
11.	“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК	Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Б.Чагнаадорж